# Сэдэв: Инкотермсийн CPT нөхцөл



2018 он

# БАРАА, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХҮРГЭЛТИЙН ЕРӨНХИЙ ЗУРАГЛАЛ

EXPORT DEVELOPMENT PROJECT



EXPORT DEVELOPMENT PROJECT

## ... Хүртэл тээвэрлэлт төлөгдсөн

1. Худалдагч нь бараа, бүтээгдэхүүнийг "худалдан авагчтай тохирсон хүргэлт хийх нэрлэсэн газарт хүргэх тээвэрлэгчийг өөрөө сонгон тээвэрлэлтийн гэрээ хийж тээврийн зардлыг нь төлж бараа, бүтээгдэхүүнийг хүргэх" нөхцөл.
2. Хүргэлт хийхээр тохирсон нэрлэсэн газар – Худалдагч бараа, бүтээгдэхүүнээ хүргэхээр худалдан авагчтай тохирсон нэр, хаяг бүхий газар. Энэхүү нэрлэсэн газар нь экспортлогч эсвэл импортлогч улсын нутагт байж болно. Жишээ нь ачих боомтыг (экспортлогч улсын) эсвэл очих боомтыг (импортлогч улсын) нэрлэсэн газраар сонгож болдог. Нэрлэсэн газрыг худалдааны гэрээндээ тодорхой тусгана.



# CPT НӨХЦӨЛИЙН ТЭЭВЭРЛЭЛТ, ХҮРГЭЛТ

Худалдагч нь тээвэрлэгчийг өөрөө сонгон тээвэрлэлтийн гэрээ хийж тээврийн зардлыг нь төлж бараа, бүтээгдэхүүнийг худалдан авагчтай тохирсон хүргэлт хийх нэрлэсэн газарт хүргүүлнэ




- Хүргэлт хийхээр тохирсон нэрлэсэн газар гэдэг нь худалдагч бараа, бүтээгдэхүүнээ хүргэхээр худалдан авагчтай тохирсон нэр, хаяг бүхий газар. Энэхүү нэрлэсэн газар нь экспортлогч эсвэл импортлогч улсын нутагт байж болно. Жишээ нь нэрлэсэн газар нь импортлогч улсад байгаа очих боомт байж болно. Нэрлэсэн газрыг худалдааны гэрээндээ тодорхой тусгана.
- Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг хүргэлт хийх тохирсон газарт тээвэрлэх тээвэрлэгчийг өөрөө сонгож томилдог. Тээвэрлэгч нь тээврийн хэрэгсэл бүхий хувь хүн эсвэл тээврийн компани байж болно.

# СРТ НӨХЦӨЛИЙН ОНЦЛОГ ТАЛУУД

- Эрсдэл, зардал өөр газарт худалдагчаас худалдан авагч руу шилждэг.
- Талууд эрсдэл шилжих цэг буюу хүргэлт хийх газар, байршлыг маш сайн тохирох шаардлагатай.
- Худалдагч нь бараа, бүтээгдэхүүнийг өөрийн гэрээт тээвэрлэгчид өгснөөр бараа, бүтээгдэхүүний алдагдал, эвдрэл, гэмтлийн эрсдэл худалдан авагч руу шилждэг. Харин тээвэрлэлтийн зардлыг хүргэлт хийхээр тохирсон газар хүртэл төлдөг.
- Худалдагч бараа, бүтээгдэхүүнийг экпортонд гаргахад шаардлагатай бүрдүүлэлт, үзлэг, шалгалтыг хариуцна.
- Бараа, бүтээгдэхүүн хүргэлтийн тээврийн хэрэгсэлд ачигдсанаас хойшхи эрсдэлийг худалдан авагч хүлээдэг. Бараа, бүтээгдэхүүний хүргэлтийг хянах боломж бага учраас хүргэлтийг хийж байгаа тээвэрлэлт, хүргэх газар зэргийн талаар худалдагчаас хангалттай мэдээлэл авах шаардлагатай.

# СРТ НӨХЦӨЛИЙН БҮДҮҮВЧ ЗУРАГЛАЛ



# СРТ НӨХЦӨЛИЙН ДАГУУ ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА, ЗАРДАЛ



| Хүлээх үүрэг хариуцлага, зардал | ХУДАЛДАГЧ | ХУДАЛДАН АВАГЧ |
|---|---|---|
| 1. Барааны баглаа, боодол, тэмдэглэгээ, шошго | ✅ | ❌ |
| 2. Экспортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалт | ✅ | ❌ |
| 3. Анхдагч тээвэрлэлт (үндсэн тээвэрлэгч рүү)-ийг гэрээлэх, төлөх | ✅ | ❌ |
| Анхдагч тээврийн хэрэгсэлд ачих | ✅ | ❌ |
| Анхдагч тээврийн хэрэгслээс буулгах | ✅ | ❌ |
| 4. Үндсэн тээвэрлэлтийг гэрээлэх, төлөх | ✅ | ❌ |
| Үндсэн тээврийн хэрэгсэлд ачих | ✅ | ❌ |
| Үндсэн тээврийн хэрэгслээс буулгах | ❌ | ✅ |
| 5. Эцсийн тээвэрлэлт (худалдан авагч руу)- ийг гэрээлэх, төлөх | ❌ | ✅ |
| Эцсийн тээврийн хэрэгсэлд ачих, буулгах | ❌ | ✅ |
| 6. Импортын гаалийн бүрдүүлэлт, үзлэг шалгалт | ❌ | ✅ |
| 7. Даатгал | ❌ | ✅ |

# CPT БОЛОН БУСАД НӨХЦӨЛҮҮД



EXPORT
DEVELOPMENT PROJECT

# АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА